



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 06 сарын 09 өдөр

Дугаар А/225

Хэрлэн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.5 "г", Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.2.3, Боловсролын тухай хуулийн 30.1.13 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Цэнхэрмандал сумын сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаа болон байрны ашиглалтад хяналт шалгалт хийх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн
ахлагч:

-аймгийн Засаг даргын Тамгын газрын
Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Нарийн бичгийн
дарга:

-аймгийн Засаг даргын Тамгын газрын
Нийгмийн бодлогын хэлтсийн боловсрол
хариуцсан мэргэжилтэн

Гишүүд:

-аймгийн Мэргэжлийн хяналтын газрын боловсрол,
соёлын хяналтын улсын байцаагч
-аймгийн Боловсрол, соёл урлагийн газрын дарга
-аймгийн Боловсрол, соёл урлагийн газрын ахлах
мэргэжилтэн

2. Хяналт шалгалтын удирдамжийг батлуулан, хууль, тогтоомжийн хүрээнд зохион байгуулан дүнг илтгэх хуудсаар танилцуулахыг ажлын хэсгийн ахлагчид даалгасугай.

3. Захирамжийн гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ж.Ганбаатар/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

011054